



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/694

Булган сум

Биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXV хуралдааны XXV/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээ зохион байгуулахыг Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 14,799,420 (арван дөрвөн сая долоон зуун ерэн есөн мянга дөрвөн зуун хорь), Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 5,000,000 (таван сая) төгрөгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлж нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга (М.Оюунбат), Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Гончиг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний "Нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээ авах" төсөл арга хэмжээнээс гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 17-ний өдрийн А/Б.ЗН. дугаар
захирамжийн хавсралт

Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд
биотехникийн арга хэмжээнд шаардагдах төсвийн задаргаа

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгж бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Давс	кг	4400	1 800	7 920 000
2	Тэжээлийн будаа	Кг	9000	700 000	6 300 000
					14 220 000
3	Шатахуун	Литр	-	-	579 420
					14 799 420

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгж бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
Тэшиг сум (маяти машин)					
1	Шивэртийн пост (45*2 км)	литр	16	3480	55 680
2	Эг тарвагатайн бэлчир (20*2 км)	литр	7	3480	24 380
3	Харлан бөөрөг (40*2 км)	литр	14	3480	48 720
4	Улаан мод (45*2 км)	литр	16	3480	55 680
	Нийт 300 км				187 920
Хутаг-Өндөр (фермер машин)					
1	Баянголын пост (30*2 км)	литр	54	2610	140 940
2	Бэлсэгийн пост (25*2 км)				
3	Уургийн пост (20*2 км)				
	Нийт 300 км				140 940
Сэлэнгэ сум (маяти машин)					
1	Харлаг (20*2 км)	литр	100	3480	250 560
2	Тариахтайн пост (18*2 км)				
3	Харцайн пост (15*2 км)				
4	Шаврын пост (15*2 км)				
5	Баруун гол (15*2 км)				
6	Цүүцийн пост (35*2 км)				
7	Баруун хужирын пост (82*2 км)				
	Нийт 400 км				250 560
	Нийт 1000 км				579 420

Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд биотехникийн
арга хэмжээнд шаардагдах төсвийн задаргаа

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгж бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Өвс	Ш	320	12 500	4 000 000
2	Давс, Хужир	Тонн	2	500 000	1 000 000
	Нийт дүн				1 000 000